



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК

2026 оны 03 дугаар сарын 11

Багануур дүүрэг

Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилтийн явц:

Нийслэлийн 2022 оны төсөвт 2474,1 сая төгрөг тусгагдаж гүйцэтгэгчээр “Энх өглөө” ХХК нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан тус ажлыг гүйцэтгэсэн. Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний А/206 дугаар тушаалын дагуу Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж шугамыг ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16мВА чадалтай үндсэн дэд станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Эм Ай Эс Эс” ХХК нь 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Нийслэлийн засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1130 захирамжаар паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил, Паркийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шинэчлэн боловсруулах 80.0 сая.төг-ийг шийдвэрлэсэн.

- Паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахаар Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв НҮТББ шалгарч нийслэлийн Засаг даргын Тамгын газартай 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн НХААГ/20250203701 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгэж байна.
- Паркийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шинэчлэн боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Нийслэлийн засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн А/100 захирамжаар Паркийн үйлдвэрийн албан конторын барилгын засварын зураг төслийн 46.8 сая.төг санхүүжилт шийдвэрлэгдсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Нийслэлийн засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн А/100 захирамжаар Паркийн үйлдвэрийн албан конторын барилгын засварын зураг төслийн 46.8 сая.төг санхүүжилт шийдвэрлэгдсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Мэдээлэл өгөх ажилтан:
Үйлдвэрлэл, технологийн хэлтсийн
дарга Б.Мөнгөнхуяг.
Утас: 88656964